



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/618

Арвайхээр

**Түр зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г”, “л” заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээний газруудад иргэдийн гаргасан хүсэлтийг үндэслэн тогтоосон цагийн хуваарийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Баасан” гарагт архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг түр зөвшөөрсүгэй.

2. Дээрх тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээний газруудад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-нд тус тус даалгасгай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011101145